

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны ... дугаар сарын ...-ны өдрийн дугаар тушаалын хавсралт

НЭГ МАЛ ЗҮЙЧИД НООГДОХ МАЛЫН ТОО

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Энэхүү журмаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа аймаг, нийслэлийн Мал үржлийн алба, сум дүүргүүдийн Хөдөө аж ахуйн тасаг, хувийн хэвшлийн мал аж ахуй эрлхэгч аж ахуйн нэгж, Малын үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжийн мал зүйчид ноогдох малын тоог тодорхойлж мэргэжлийн ажлын үйлчилгээний чанарыг сайжруулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2 Нэг мал зүйчид ноогдох малын тоог тодорхойлохдоо ажлын чиг үүрэг, ажлын ачаалал, аж ахуй нэгжийн бүтэц, зохион байгуулалтыг харгалзан үзэв.

ХОЁР. МАЛ ЗҮЙЧИЙН ҮҮРЭГ

2.1. Аймаг, нийслэлийн Мал үржлийн албанд ажиллаж байгаа мал зүйч нь тухайн аймгийн малын үржлийн ажлын ерөнхий бодлогыг хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулах, сумдын Хөдөө аж ахуйн тасгийн мал зүйчийн ажлын удирдамж, арга зүйгээр ханган ажиллана.

2.2. Сум, дүүргийн Хөдөө аж ахуйн тасгийн мал зүйч нь аймгийн Мал үржлийн албанаас ирүүлсэн бодлого, арга зүй, удирдамжийн дагуу тухайн сумын малын үржлийн ажлыг зохион байгуулна.

2.3. Малын үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжийн мал зүйч нь сум, дүүргийн малын үржлийн ажлын бодлого, заавар, зөвлөмжийн дагуу дараах ажлуудыг гардан гүйцэтгэнэ. Үүнд:

2.3.1 Төрөл бүрийн малын ангилалт, ялган тэмдэглэлт хийх

2.3.2 Төрөл бүрийн малын зохиомол хээлтүүлэг, хөврөл шилжүүлэн суулгах

2.3.3 Бог малыг хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлэх, хээлтүүлэгч бойжуулах

2.3.4 Малчдад малын үржүүлэг, технологийн чиглэлээр сургалт, зөвөлгөө өгөх

2.3.5 Хувийн хэвшлийн мал аж ахуй эрхлэгч аж ахуйн нэгжийн мал зүйч нь тухайн аж ахуйн малын үүлдэрлэг байдал, аж ахуйн ашигт чанарыг нэмэгдүүлэх үүрэгтэй ажиллах боловч аймаг, сумын мал үржлийн ажлын бодлогын хүрээнд ажиллаж дараах ажлыг хийнэ.

2.3.5.1 Тухайн аж ахуйн малд үзлэг ангилалт, бүртгэлжүүлэлтийг хийх

2.3.5.2 Тухайн аж ахуйн малын үржлийн ажлыг улсын бодлогод нийцүүлэн зохион байгуулах

2.3.5.3 Төрөл бүрийн малд зохиомол хээлтүүлэг хийх, хөврөл шилжүүлэн суулгах

ГУРАВ. НЭГ МАЛ ЗҮЙЧИД НООГДОХ МАЛЫН ТОО

3.1. Нэг мал зүйчид ноогдох малын тоог 2.2-т заасан ажлын үүрэг, чиглэлийг үндэслэн тогтоов.

№	Хийгдэх ажил	Аймаг, нийслэлийн мал зүйч	Сум, дүүргийн мал зүйч	Хувийн хэвшлийн МАА-н компани, мал бүхий иргэдийн мал зүйч		Малын үржүүлэг технологийн ажилүйлчилгээний нэгжийн мал зүйч	
				1 хоногт	1 сард	1 хоногт	1 сард
1	Аймаг, нийслэлийн малын үржлийн бодлого гаргах, хэрэгжүүлэх	Аймаг, нийслэлийн бүх мал	Сум, дүүргийн бүх мал	-	-	-	-
2	Сум, дүүргийн Хөдөө аж ахуйн тасаг, Мал үржүүлэг технологийн ажил, үйлчилгээний нэгжийг удирдан зохион байгуулах	Аймаг, нийслэлийн бүх мал	Сум, дүүргийн бүх мал	-	-	-	-
3	Бог малд ангилалт хийх	Бүх сум, дүүргийн ангилалтын мэдээг нэгтгэх	МҮТАҮнэгжээс ирсэн тайлан мэдээг нэгдсэн санд бүртгэх	300	9000	300	9000
4	Бод малд ангилалт хийх	Бүх сум, дүүргийн ангилалтын мэдээг нэгтгэх	МҮТАҮнэгжээс ирсэн тайлан мэдээг нэгдсэн санд бүртгэх	200	6000	200	6000
5	Үхрийн зохиомол хээлтүүлэг хийх	Бүх сум, дүүргийн зохиомол хээлтүүлгийн мэдээг нэгтгэх	МҮТАҮнэгжээс ирсэн зохиомол хээлтүүлгийн тайлан мэдээг нэгдсэн санд бүртгэх	50	1500	50	1500

6	Бог малын зохиомол хээлтүүлэг хийх	Бүх сум, дүүргийн зохиомол хээлтүүлгийн мэдээг нэгтгэх	МҮТАҮнэгжээс ирсэн зохиомол хээлтүүлгийн тайлан мэдээг нэгдсэн санд бүртгэх	150	4500	150	4500
7	Ялган тэмдэглэх	Бүх сум, дүүргийн ээмэгжүүлэлтийн мэдээг нэгтгэх	МҮТАҮнэгжээс ирсэн ээмэгжүүлэлтийн тайлан мэдээг нэгдсэн санд бүртгэх	1000	30000	1000	30000
8	Чип суулгах	Бүх сум, дүүргийн бүртгэлжүүлэлтийн мэдээг нэгтгэх	МҮТАҮнэгжээс ирсэн Бүх сум, дүүргийн бүртгэлжүүлэлтийн мэдээг нэгтгэх тайлан мэдээг нэгдсэн санд бүртгэх	200	6000	200	6000
Нийт				1900	57000	1900	57000